



ГОВЬСҮМЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШАА I

2024 оны 05 сарын 16 өдөр

дугаар А/08

Баянтал сум

Хяналт, шалгалт, үнэлгээ хийх ажлын хэсэг
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, аймгийн Засаг даргын 2021 оны А/147 дугаар захирамжаар батлагдсан “Баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.2024 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд явцын хяналт, шалгалт, үнэлгээ хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн дарга:

Л.Отгонпүрэв

(Засаг даргын Тамгын газрын Санхүү
албаны дарга)

Ажлын хэсгийн гишүүд:

С.Оюунтүлхүүр

(Засаг даргын Тамгын газрын
Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл
хоршооны асуудал хариуцсан
мэргэжилтэн)

Н.Мөнгөнцэцэг

(Засаг даргын Тамгын газрын
Архив бичиг хэргийн эрхлэгч)

Ш.Шинэбаяр

(Засаг даргын Тамгын газрын
Байгаль орчин хариуцсан
мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:


М.Бодьгэрэл


(Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлого, худалдан авах
ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2.2024 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд явцын хяналт, шалгалт, үнэлгээ хийх удирдамжийг хавсралтаар баталсугай.

3.2024 оны 05-р сарын 25-ны өдрийн дотор хяналт шалгалт, үнэлгээ хийж,

үр дүнг Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсгийн дарга (Л.Отгонпүрэв)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  ХИШИГНЯМ





ГОВЬСҮМБӨР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШАА I

2024 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 409

Баянтал сум


Хүүхэд хамгааллын бодлого батлах
тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4, 30.1.19, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/110 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Засаг даргын Тамгын газрын стратеги төлөвлөгөө (2021-2024 он) хэрэгжүүлэх хүрээнд "Засаг даргын Тамгын газрын алба хаагчдын хүүхэд хамгааллын бодлого"-ыг хавсралтаар баталсугай.

2.Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэнд үүрэг болгосугай.

3.Байгууллагын алба хаагчдын хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт тавьж, ажлын тайланг жил бүрийн 12 дугаар сарын 05-ны өдрийн дотор танилцуулахыг Нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтэн (М.Бодьгэрэл)-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОНГҮЙЦЭТГЭГЧ  Т.ХИШИГНЯМ

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН АЛБА ХААГЧДЫН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БОДЛОГО

Нэг. Нийтлэг үндэслэл

НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц, Монгол Улсын Үндсэн хууль, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хуний эрхийн тухай хуулиудын хүрээнд хүүхэд нийгмийн бүх орчинд, хүчирхийллийн бүх хэлбэр /дарамт, хүчирхийлэл, мөлжлөг, үл хайхрах явдал/ээс хамгаалуулах эрхтэй бөгөөд насанд хүртлээ эцэг эх, гэр бил болон төрийн онцгой халамж, хамгаалалтад байх шаардлагатай болохыг хуульчилсан.

Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсэг "Ажил олгогч нь ажил, амралтын цагийг зохицуулах, хөдөлмөр эрхлэлтийн уян хатан нөхцөл хэрэглэх зэргээр ажилтны ажил, амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх, хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод журамд тусгах замаар ажилтны хүүхдэд ээлтэй, хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлэх", Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны "Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх үлгэрчилсэн заавар батлах тухай" А/110 дугаар тушаалаар байгууллагын алба хаагчдын хүүхэд хамгааллын асуудлыг тус тус хариуцна.

Засаг даргын Тамгын газрыналба хаагчдын хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлснээр хүүхдийг болзошгүй эрсдэл, хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлж, эцэг эх, асран хамгаалагч, ажилтан, албан хаагчдын хүүхэд хамгааллын талаарх ойлголт нэмэгдэнэ. Байгууллагын орчинд хүүхдэд ээлтэй орон зай бий болно. Алба хаагчдын хүүхдүүддээ санаа зовох байдал буурснаар ажлын бүтээмж нэмэгдэж, хамт олны дунд эерэг дулаан уур амьсгал бүрдэнэ.

Хоёр. Зорилго

Засаг даргын Тамгын газрыналба хаагчдын гэр бүл, нийгмийн хүрсэнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах болон хүүхдийг эрсдэлтэй нөхцөлд орохоос урьдчилан сэргийлэх, хүчирхийллээс хамгаалах, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэхэд оршино.

Гурав. Хүүхэд хамгааллын бодлогын зарчим

- 3.1. Хүүхдийн эрхийг дээдлэн, нэр төрийг хүндэтгэх.
- 3.2. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрөхгүй байх.
- 3.3. Хүүхдэд хор хөнөөл учруулахгүй байх. 3.4. Ялгаварлан гадуурхахгүй байх.
- 3.5. Хүүхдийн дээд ашиг сонирхолд нийцүүлэх, нууцлалыг хамгаалах. 3.6. Хүүхэд хамгаалалд харилцан хариуцлага хүлээх, хүүхдийг хайрлах.
- 3.7. Эрсдэлийг тооцох, урьдчилан сэргийлэх.

Дөрөв. Хамрах хүрээ

Энэхүү баримт бичиг нь Засаг даргын Тамгын газрын нийт алба хаагч, ажилтан, сонсогч, гэрээт ажилтан, тэдний гэр бүлийн гишүүдэд хамаарна.

Тав. Алба хаагчдын мөрдөх ёс зүйн хэм хэмжээ, үүрэг

Засаг даргын Тамгын газрын удирдлага, алба хаагчид, болон бусад хүмүүс дараах ёс зүйн хэм хэмжээг мөрдлөгө болгоно.

Ажилтан, алба хаагчдын хориглох зүйл:

1. Хүүхдийг цохих, зодох тусгаарлах зэргээр бие махбодын хучирхийлэл үйлдэх;
2. Хүүхдийг гутаах, ичээх, доромжлох, дорд үзэх, нэр хоч өгөх, сэтгэл зүйн дарамт учруулах зэргээр сэтгэл санааны хүчирхийлэл үйлдэх;
3. Хүүхдийг садар самуунд уруу татсан үйлдэл гаргах, шалиг, зүй бус үг хэллэг хэрэглэж харьцах;
4. Хүүхдийн дэргэд зохисгүй үг хэрэглэх;
5. Хүүхэд хүчирхийлэлд өртсөн, аюултай нөхцөл байдалд орсон тохиолдолд мэрээлэхгүй орхих;
6. Хүүхдийн зураг, дүрс, мэдээллийг эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрөлгүй цахим сулжээ (Фейсбүүк, твиттер гэх мэт)-нд нийтлэх;
7. Бага насны хүүхдийг асран хамгаалах хүнгүй, хараа хяналтгүй орхихгүй байх;
8. Бага насны хүүхдийг гэр, ажлын байр, автомашин болон бусад газар цоожлон орхихгүй байх;
9. Хүүхдийг харж асрах хүнгүй гол, мөрөн, нуур, тогтоол ус, уул хаданд явуулахгүй байх;
10. Ажилтан, алба хаагчтай хүүхдийн өмнө дээрэнгүй, зандарч харилцах, зүй бус хараалын үг хэрэглэхгүй байх;
11. Хувийн нууцад хамаарах мэдээллийн хувиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд байгууллага, албан тушаалтан, хувь хүнд хүүхдийн мэдээллийг өгөхгүй байх;

Байгууллагын хориглох зүйл:

1. Байгууллагын хүүхэд хамгааллын бодлогыг зөрчиж байгаа нь мэдэгдсэн боловч мэдээгүй мэт өнгөрөөх, нуун дарагдуулах;
2. Хүүхдийг ямар нэгэн хөдөлмөрт хөлслөх;
3. Эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрөлгүйгээр хүүхдийг урлаг, спортын арга хэмжээнд оролцуулах;
4. Ёс заншил, шашны болон зан үйлийн хэлбэртэй үйл ажиллагаанд оролцуулах;
5. Ажлын байр, хүүхдийн орчинд архи, тамхи сэтгэцэд нөллөөлөх эм, тариа, мансууруулах бодис хэрэглэх;

Хүүхэд хамгааллын талаар хүлээх үүрэг:

1. Байгууллагын ажилтан бүр хүүхдийн эсрэг аливаа хүчирхийлэл, мөлжлөгийн талаар байгууллагын удирдлага, эцэг эхийн зөвлөлд мэдээлэх, зөвлөл нь хүүхэд хамгааллын зөрчлийг хүлээн авах үүрэгтэй.
2. Ажилтан, алба хаагч хүүхэд хамгааллын ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн болон зөрчсөн байж болзошгүй үйлдэл, зан үйлийн талаар мэдээлэх.

3. Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх нь Засаг даргын Тамгын газрын нийт албан хаагчдын үүрэг байна.

Зургаа: Зохион байгуулалт

6.1 Аймгийн хүүхэд гэр бүл хамгааллын газар хүүхэд хамгааллын асуудлаар ажиллах Эцэг эхийн зөвлөлийг байгуулж ажиллана.

6.2 Эцэг эхийн зөвлөлийг удирдах ажилтан, албан тушаалтны төлөөлөл бүхий 3,5,7-н хүний бүрэлдэхүүнтэй 1 жилийн хугацаатай байгуулна.

6.3 Эцэг эхийг зөвлөл нь улиралд 1 удаа хуралдах, шаардлагатай тохиолдолд төлөвлөгөөт бусаар хуралдаж болно.

6.4 Эцэг эхийн зөвлөл нь хийх ажлын төлөвлөгөөг 1 жилийн хугацаатайгаар гарган зөвлөлийн даргаар батлуулж, хэрэгжилтийн тайланг жил бүрийн 11 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Хяналт шалгалтын газар, Хяналт, шинжилгээ үнэлгээний асуудал хариуцсан нэгжид тайлагнана.

Долоо. Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

Засаг даргын Тамгын газрын хүүхэд хамгааллын бодлогын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Уунд:

7.1 Урьдчилан сэргийлэх:

7.1.1 Алба хаагчдад хүүхдийн эрх, аюулгүй байдал, хүүхдийн онцлог, хэрэгцээ, шаардлага, цахим халдлагаас урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээг 4-өөс доошгүй удаа үе шаттайгаар зохион байгуулах.

7.1.2 Алба хаагчдын гэр бүлийн хүчирхийлэл болон хүүхдийн хүчирхийлэл үйлдэгдэж байгаа эсэх, хүүхдүүдийн талаар дэлгэрэнгүй судалгааг гаргаж, хариу арга хэмжээ авах.

7.1.3 Сургуулийн орчинд эцэг, эхийн эргүүлд томилогдох уед, эцэг эхийн хуралд алба хаагчдыг ажлаас чөлөөлөх.

7.1.4 Эцэг, эх нь хоёулаа албанд хамт ажилладаг алба хаагчид, Эмэгтэй алба хаагчдыг 7 хоногийн 1 өдөр ажлын богиносгосон цагаар ажиллуулах

7.1.5 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй алба хаагчдын хүүхдүүдийг бэрхшээлийн төрлөөс хамааруулан жилд 1-ээс доошгүй удаа эмнэлгийн үзлэг оношилгоо, сувилал, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвд хэвтэхэд дэмжлэг үзүүлэх.

7.2 Хүүхдийн аюулгүй орчныг бүрдүүлэх

7.2.1 Байгууллага дээр хүүхдийн өрөө, тасалгаа, цэцэрлэг байгуулах, хүүхдэд эдтэй орчныг бүрдүүлэх.

7.2.2 Гамшиг, ослын дуудлага, албан томилолтоор удаан хугацаанд (5-аас дээш хоног) явж буй алба хаагчдын хүүхдийн аюулгүй байдалд анхаарал хандуулах, ар гэрт нь бололцоот дэмжлэг үзүүлэхэд анхаарах.

7.3 Мэдээлэх

7.3.1 Алба хаагчдын хүүхдийн эрхийн зөрчлийн талаарх мэдээллийг 24 цагийн дотор холбогдох байгууллага, хариуцсан хүмүүст нь албан ёсоор мэдэгдэнэ.

7.4 Арга хэмжээ авах

7.4.1 Хүүхэд дарамт, хүчирхийлэлд эртсэн буюу өртөж байж болзошгүй нь мэдэгдвэл хүүхдийг хамгаалах, дэмжиж туслах, ажилтнуудад хариуцлага тооцох